



СҮХБААТАР АЙМГИЙН
СҮХБААТАР СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Хайлаастай, Сүхбаатар сум, 22030

2025.04.08 № 01/109
танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД

Тус сумын нутагт орших “ЗАРАА” гэх газарт хайлуур жоншны ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг, MV-017194 тоот тусгай зөвшөөрөлтэй “АНАНД БАЯН ТАЛ” ХХК нь 2024 онд ашиглалтын болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулаагүй болно.

ДАРГА



ЦАРИУНЦОГ

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	9
4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 15	
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд.....	3
Хүснэгт 2. Болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	10
Хүснэгт 3. Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал	11
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	20
Хүснэгт 7. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт 10. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
Хүснэгт 11. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө	26
Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа	27

Зургийн жагсаалт

Зураг 1. Ашиглалтын систем	4
Зураг 2. Бичигтийн боомт хүртэл тээвэрлэх маршрут	4
Зураг 3. Бор-Өндөр хүртэл тээвэрлэх маршрут	5

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Зараа” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Анандбаян тал” ХХК /улсын бүртгэлийн дугаар: 9011141103, регистрийн дугаар: 5218624, албан ёсны хаяг: Баянзүрх, 14-р хороо, Консулын, 512 тоот, утас: 91912719

Төслийн байршил: “Анандбаян тал” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын “Зараа” нэртэй хайлуур жоншны орд MV-017194 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь 94 га талбайг хамран оршино. Улаанбаатар хотоос 520 км Баруун-Урт хотоос зүүн тийш 20 км Сүхбаатар сумын төвөөс баруун тийш 35 км-т байрлана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд


№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	113	29	32.24	46	39	14.73
2	113	29	32.25	46	39	41.75
3	113	28	39.24	46	39	41.75
4	113	28	39.24	46	39	14.73

Ордыг ашиглах тусгай зөвшөөрөл: Тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2012 оны 10 сарын 22-ний өдрийн тушаалаар MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Анандбаян тал” ХХК-д 2042 оны 10 сарын 22-ний өдрийг хүртэл олгосон.

Ашиглалтын систем: Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөл, түүнчлэн ижил төстэй ордуудыг ашиглаж байгаа дэлхийн бусад улс орнуудын практик туршлага зэргийг үндэслэн Зараагийн хайлуур жоншны ордын ашиглалтад хамгийн тохиромжтой нь хүдэр хоршоолох ашиглалтын систем байна.


Хүдэр хоршоолох, шпурын цэнэгийн аргаар нураах ашиглалтын систем нь бага зузаантай босоо уналтай ордод хэрэглэхэд хамгийн тохиромжтой байдаг.

Хүдэр хоршоолох ашиглалтын систем хэрэглэх үед блок хоорондын хамгаалалтын цул, блокийн дээд хамгаалалтын цул, штрекний дээд хамгаалалтын цулыг үлдээх бөгөөд хүдэр нураалтын ажлыг 1.2-1.4 м өндөртэй хэвтээ үеэр зохион байгуулна. Хүдэр хоршоолох ашиглалтын систем нь аваар осол багатайгаас гадна мөргөцгийн ажилчны хөдөлмөрийн бүтээмж өндөр, ашиглалтын хаягдал, бохирдол бага байдаг.




Зураг 1. Ашиглалтын систем

Уурхайн тээвэр: Зараагийн уурхайгаас гарах баяжмалыг нэгдүгээрт Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Бичигтийн боомт хүртэл, хоёрдугаарт Сүхбаатар аймгийн Бор-Өндөр сум хүртэл авто, цаашаа Замын-Үүд боомт хүртэл төмөр замаар тээвэрлэх 2 хувилбараар тээвэрлэхээр төлөвлөсөн байна. Автотээврээр тээвэрлэхэд Бичигтийн боомт хүртэл 268 км, Бор-Өндөр хүртэл 360 км зайтай байна.



Зураг 2. Бичигтийн боомт хүртэл тээвэрлэх маршрут



Зураг 3. Бор-Өндөр хүртэл тээвэрлэх маршрут

Ухаж ачих, тээвэрлэх процесс: Зараагийн орд нь 2014 онд олборлолтын үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд жоншны үнэ, хөрөнгө оруулалт зэргээс хамааран дийлэнх хугацаанд зогсонги байдалтай байсан. Одоогийн байдлаар зараагийн уурхайд 15кВ-ын дэд станц, уурхайн тосгон, гүний худаг, далд уурхайн тоног төхөөрөмжүүд зэрэг шаардлагатай хөрөнгө оруулалтууд хийгдсэн, ашиглалтад бэлтгэгдсэн байна.

Дэд бүтэц: Зараа-6 орд нь Чингис хотоос 98 км, Сүхбаатар сумаас баруун зүгт 21 км-т орших бөгөөд ордын урд талаар УБ-Дорнод хүртэл хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг.

Уурхайн цахилгаан хангамж: Одоогоор уурхайд 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 250 кВА-н дэд станц суурилагдсан бөгөөд хүчин чадлыг өргөтгөж бүх хэрэглэгчдийг 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээх 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 1,000 кВА-н дэд станц суурилуулахаар төлөвлөсөн байна.

Уурхайн усан хангамж:

- Өрөмдмөл гүний худаг
- Усны ундарга 3.8 л/сек

Өрөмдлөг тэсэлгээний ажил: Тус орд нь судал хэлбэрийн, уналын өнцөг хайгуулын зүсэлтүүдээс үзэхэд 70-80°, агуулагч чулуулаг ба хүдрийн биетийн тогтворжилт нь тогтвортойгоос дунд зэрэг хүртэл, чулуулгийн хатуулаг нь проф.Протожьяконовын ангиллаар

$f = 8-14$ байна. Уг үзүүлэлт мөнх хүдрийн биетийн зузаанаас харахад хүдрийг шпурэн цэнэгийн аргаар нураах, хүдэр хоршоолох ашиглалтын системийг сонгох таатай нөхцөл болж байна.

Малталт нэвтрэлт, хүдэр нураалтын ажилд хэрэглэгдэх өрмийн машиныг сонгохдоо далд уурхайн хүчин чадал, ашиглалтын систем, хүдрийн зузаан, чулуулгийн өрөмдөгдөх чанар, хатуулаг зэрэг үзүүлэлтүүдээс хамааруулан богино хугацаанд өндөр бүтээлтэй техник, тоног төхөөрөмж сонгох нь зайлшгүй шаардлагатай. Иймээс үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлтийн ажилд болон хүдэр нураалтын ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн YТ-28 маркийн (перфоратор) гар өрмийн машин хэрэглэхээр сонгосон болно. Энэхүү гар өрмийн машин нь босоо, хэвтээ, налуу малталтуудад болон нураалтад бүгдэд нь хэрэглэх боломжтойгоороо давуу талтай.

Уурхайн ажиллах горим: Уурхай нь бүтэн жил тасралтгүй ажиллах бөгөөд зайлшгүй амрах хоног болон өвлийн улирлын сул зогсолтуудыг доорх хүснэгтэнд үзүүлээ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 3 ээлжээр 8 цагаар явагдана.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хог хаягдлын менежмент: Уурхайн ажилчдын тосгоны хэмжээнд үүсэх хатуу хог хаягдлыг ахуйн болон машин техникээс сольсон сэлбэг хэрэгслийн гаралтай хаягдал гэж 2 үндсэн хэсэгт хувааж болно. Уул уурхайн ажилчдын тосгоны хувьд ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, гал зуух, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн томоохон объектуудаас хуралддаг. Уурхайн 2 ээлжээр ажиллах 50 ажилчидтай байх бөгөөд нэг ажилчнаас хоногт дунджаас 0.3 кг ахуйн хатуу хог хаягдал гарна гэж үзвэл хоногт 15 кг, жилд 4500 кг нийт ашиглалтын хугацаанд 22500 кг хаягдал гарна. Уурхайн үйл ажиллагааны явцад ажилчдын өдөр тутмын ундааны сав, баглаа боодол, цаас, гялгар уут зэрэг ахуйн хатуу хог хаягдлууд гарах болно.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Сүхбаатар сум нь Монгол орны зүүн бүсэд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хойд хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос зүүн зүгт 520 км, аймгийн төв Баруун-Уртаас 20 км, Эрдэнэцагаан сумын нутагт орших хилийн Бичигт боомтоос 268 км-ийн зайтай оршдог. Мөн улсын хөгжлийн гол тэнхлэг-Мянганы замаас 141 км, бүсийн хөгжлийг тэтгэх босоо тэнхлэгээс 5 км-т /төлөвлөлтөд тусгагдсанаар/ тус тус оршдог. Сумын нутаг дэвсгэрийн баруун урд талаар Уулбаян, Халзан сумдуудтай, баруун талаараа Мөнххаан сум, хойд талаараа Дорнод аймгийн Булган, Хөлөнбуйр сумдуудтай, зүүн талаараа Дорнод аймгийн Матад, зүүн урд талаараа Эрдэнэцагаан сумтай, урд талаараа Асгат сумтай тус тус хиллэдэг.

Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Нутгийн ихэнх хэсэг нь хадлан тэжээл бэлтгэх, мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой зөөлөн хүрэн бор хөрстэй. Талбулаг, Дүнгэндэг зэрэг рашаан, ус, Бүрдэнэ говь, Их цагаан зэрэг хүнсний давсны нөөц арвинтай газрууд, барилгын төрөл бүрийн зориулалтаар ашиглах боломж бүхий шавар, зосны илэрц, Талбулаг, Салхит, Салаа, Арын нуур, Алтат, Төмөртэй, Тугалбулаг, Дөхөм зэрэг нүүрс өнгөт металлын судлагдсан ордтой.

Хөрс, хөрсөн бүрхэвч: Зараа” хайлуур жоншны орд байрлах Сүхбаатар сумын нутаг нь Төв Азийн их муж Хангайн дэд муж Монгол дорнодын тойрогт хамаарагддаг байна. Тус нутгийн хөрс нь делюви, элюви, аллювийн хурдас дээр үүсч тогтсон. Хүрэн хөрс нь ихэвчлэн делювийн хөвсгөр хурдас дээр, уулын хөрс нь элювийн хурдас дээр, голын хөндийн хөрс нь аллювийн жижиг бөөрөнхий хайрга чулуун дээр үүссэн.

Хар хүрэн хөрс нь Сүхбаатар сумын 2% ийг эзэлнэ. Дангаараа үргэлжилсэн бүс үүсгэж чадахгүй алаг цоог тархана. Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан нь дунджаар 32-38см-ын хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл 32-37см-ийн гүнээс ажиглагдана, хөрсний давхаргад гөлтгөнө огт байхгүй. Хар хүрэн хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Делювийн хурдас дээр үүсч тогтсон хар хүрэн хөрс нь дээд давхарга нь бараан хүрэн өнгөтэй, бөөмөнцөр бүтэцтэй, ялзмагт үе нь нэлээн зузаан, хөрсний давхарга нь нягтарч дагтаршсан хайрга чулуу харьцангуй бага, 45-50см-ийн гүнээс карбонатлаг бөөгнөрөл нь үгүй болно.

Хүрэн хөрс нь Сүхбаатар сумын 80% ийг эзэлнэ. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог тэгш тал газраар тархсан байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал: Гол тархах бүлгэмдэл нь Хялганат – хазаар өвс, Хялганат – агь, Хазаар өвст – хялгана - алаг өвс, Хялгана хиагт – алаг өвс, Үетэнт – хазаар өвс эвшлүүд юм. Нам хотос, нарийн хөндийгөөр сийрэгдүү дэрс бүхий улалж – хиагт эвшил бас

зонхилон ургадаг. Бяруутын район нь сумын нутгийн төв ба хойт хэсгүүдээр нэлээд их хэмжээний талбайг эзлэх бөгөөд ихэнх бэлчээр нь энд хамаарна. Зүүн хойт чиглэлд сунаж тогтсон нам хотос, хоолойнууд болон тэдгээрийн хооронд орших тэгш ба долгиорхог талууд өргөн уудам нутгийг хамарна. Хотос, хоолой нь маш аажмаар тэгш талруу шилжинэ. Энд алаг цоог, хужир мараат цагаан өнгийн шаварлаг толбууд болон жижиг тойрмууд элбэг тохиолдоно. Гол төлөв дэрс, зарим газраар Бударгана, Таана зонхилон Хиаг, Агь шарилж элбэг ургадаг. Сүхбаатар сумын нутагт Хялганат–хазаар өвст, жижиг үетэн–хялгана–агьт (шарилжит) Хялгана–сөөгт, Хялгана – хиагт, Хялгана – хиаг – алаг өвст, Хиаг - дэрст эвшлүүд тохиолдоно.

Усзүйн сүлжээ: Төслийн талбай нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд, Мэнэнгийн талын сав газарт тус тус багтана. Сүхбаатар нь ус зүйн мужлалаар ус багатай бүст багтах бөгөөд гадаргуугийн ус ховортой, тогтмол урсгалтай гол мөрөн байхгүй боловч 20 гаруй жижиг нуур, 200-гаад булаг шанд, гол горхи байдаг.

Сүхбаатар , Хянганы бүсэд тунадас элбэг, гол мөрний сүлжээ шигүү байхад Хэрлэнгээс урагших ухаа гүвээт тал болон Баруун-Урт орчмын цав толгод газарт байнгын урсгалтай гол горхи бараг үгүй юм. Судалгааны баримтаас үзэхэд Хэрлэнгээс урагш орших хуурай хээр тал газарт урсацын модуль 0.1 л/с-ээс бага болох бөгөөд гол горхийн үндсэн тэжээл нь хур тунадас, гүний ус байна. Сүхбаатар аймгийн нутгийн хойд хэсгээр Хэрлэн гол эмжээрлэн урсах бөгөөд зүүн өмнөд, өмнөд хэсэг Чоногол, Харгилтай, Баян зэрэг гол горхи элбэгийн зэрэгцээ Ганга, Дагшин, Дуут, Өөшийн Цагаан нуурууд мөн Тал булаг, Цавчирын зэрэг рашаантай. Сүхбаатар аймагт гадаргын болон худаг уст цэгийн тооллогыг 2014 онд зохион байгуулсан дүнгээс үзэхэд нийт гол горхи 69, булаг 307, рашаан 6, нуур 180, худаг 1762, цэвэрлэх байгууламж 2, үерийн хамгаалалтын далан 1, услалтын систем 2, цооног 16 тус тус тоологдсоноос гол горхи 14, нуур 27, булаг шанд 29 тус тус ширгэсэн дүн гарсан нь ус ашиглалт ба усны хэрэглээ харьцангуй бага боловч уур амьсгалын өөрчлөлт, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр усны горим, нөөц, чанарт өөрчлөлт орж хомсдож байгааг илэрхийлнэ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эруул мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Төслийн хүрээнд төлөвлөж буй далд уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бутцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ.

Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл: Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах эрсдэлтэй байна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн

ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийг хэрэгжүүлэхд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим: Аливаа төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруудах замаар хэрэгждэг. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байна, байхгүй гэсэн зарчмаар үнэлэх бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ уг үнэлгээнд оролцсон шинжээч, судлаачдын дүгнэлтийг үндэслэн 2 төрлийн жагсаалт гаргасан. Нөлөөллийн хэлбэр нь үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь “шууд”, “шууд бус”, “буцаж нөлөөлөх”, “буцалтгүй нөлөөлөх”, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд “богино хугацааны”, “урт хугацааны”, эрчмийн хувьд “бага зэрэг”, “дунд”, “хүчтэй” гэхчилэн ангилсан магадлах жагсаах аргаар тодорхойлсон. Доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2. Болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зураг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Газрын доорх усны чанар		х		х			х	х		
2	Газрын доорх усны нөөц		х			х		х	х		
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х	х		х		
4	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х								
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
5	Усны чанар, хэмжээ		х		х		х			х	
6	Агаарын бохирдол		х		х			х	х		
7	Хөрсний бохирдол		х			х	х		х		
8	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		х		х			х		х	

*Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших “Анандбаян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур
жоншны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

9	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	х							х		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
10	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл	+				+		+		+	
11	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөл										
12	Хүн, амын орлого нэмэгдэх	+				+		+		+	
13	Хүн амын тоо өөрчлөгдөх										
Эдийн засаг, байгаль орчин											
14	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+		+		+		+	
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+		
17	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
18	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+		
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөл		х		х		х			х	
Бусад нөлөөлөл											
20	Хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих		х		х		х		х		
21	Нөлөөллийн тоо ширхэг	Сөрөг	2	9		6	3	5	4	7	3
		Эерэг	6	1	1	1	6	2	5	2	4
											1

Тайлбар: “+” эерэг, “х” сөрөг

Хүснэгт 3. Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал

Шууд нөлөөллийн тоо: 8	
Эерэг нөлөөлөл нь: 6	Сөрөг нөлөөлөл нь: 2
- Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	- Хөрсний элэгдэл, эвдрэл - Дуу чимээ, шуугианы нөлөө
Шууд бус нөлөөллийн тоо: 10	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь: 9
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	- Газрын доорх усны чанар - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол - Хөрсний бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөл - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих
Өөрөө зохицуулагдах нөлөөллийн тоо: 1	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь:
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	
Богино хугацааны нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 6	Эерэг нөлөөлөл нь: 1

*Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших “Анандбаян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур
жоншны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

– Усны чанар, хэмжээ – Агаарын бохирдол – Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл – Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх – Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	– Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Урт хугацааны нөлөөллийн тоо : 9	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 6
– Газрын доорх усны чанар – Хөрсний элэгдэл, эвдрэл – Хөрсний бохирдол	– Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх – Хүн, амын орлого нэмэгдэх – Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх – Орон нутгийн орлого нэмэгдэх – Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох – Ажлын байр нэмэгдэх
Буцах нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 5	Эерэг нөлөөлөл нь: 2
– Хөрсний элэгдэл, эвдрэл – Усны чанар, хэмжээ – Хөрсний бохирдол – Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх – Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	– Ажлын байр нэмэгдэх – Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Буцалтгүй нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 4	Эерэг нөлөөлөл нь: 5
– Газрын доорх усны чанар – Газрын доорх усны нөөц – Агаарын бохирдол – Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл	– Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх – Хүн, амын орлого нэмэгдэх – Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх – Орон нутгийн орлого нэмэгдэх – Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
Сулавтар нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 7	Эерэг нөлөөлөл нь: 2
– Газрын доорх усны чанар – Газрын доорх усны нөөц – Агаарын бохирдол – Хөрсний бохирдол – Дуу чимээ, шуугианы нөлөөлөл – Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржил	– Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох – Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Дунд зэргийн нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 4
– Усны чанар, хэмжээ – Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл – Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	– Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх – Хүн, амын орлого нэмэгдэх – Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх – Ажлын байр нэмэгдэх
Эрчимтэй нөлөөллийн тоо : 1	

*Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших “Анандбаян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур
жоншны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

Сөрөг нөлөөлөл нь: 0	Эерэг нөлөөлөл нь: 1
	— Орон нутгийн орлого нэмэгдэх

4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ананд баян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
АГААРЫН ЧАНАР									
1	Уурхайн тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед зам талбайн усалгаа хийх	Уурхайн дотоод зам талбай	-	-	-	3.910	Тоосжилт ихтэй үеүдэд	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль;
2	тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008
3	хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй	Замын маршрутын дагуу хурдны тэмдэг тэмдэглэгээ тавих	Уурхайн дотоод зам талбай	-	-	-	1.5	2025 онд	Бензин хөдөлгүүртэй авто машин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009
4	машинуудаас ялгарах хорт бодисуудаар	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийх	Төслийн явцад	-	-	-	2.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Дизель хөдөлгүүртэй авто машин- Утааны тортогжилтын

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөл-лийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжү үлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
5	орчны агаар бохирдох	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	-	-	-	1.0	2025 онд	зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
6		Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангаж ажиллах	Нийт ажиллагсдад	-	-	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан	2025 онд	
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ									
7	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, хүнд даацын машин	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх	Төслийн талбай	-	-	-	1.0	2025 онд	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт. MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах.
8	механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	Хог хаягдлыг ангилан ялгах, битүү тагтай саванд хуримтлуулж тухай бүрт нь хогийн цэгт хаях	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-	-	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан	2025 онд	
9	Шатах тослох материал, барилгын материалын хог	ШТМ-ын стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Төслийн талбай	-	-	-	0.39	2025 онд	

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөл-лийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжү үлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
10	хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Төслийн явцад	-	-	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан	Сургалт жилд 1 удаа	Техникийн ерөнхий шаардлага
11		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	
ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ									
12	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Төслийн явцад	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
13		Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдваргүйжүүлэлт	Ажилчдын байрны хүрээнд	-	-	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан	Сард 1 удаа	

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур жоншны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөл-лийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжү үлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
АМЬТНЫ АЙМАГ									
14	Авто машины зогсоол, засварын цех	Осол гарч болзошгүй мал, амьтан өнгөрөн гардаг хэсгүүдэд тэмдэглэгээ байрлуулах	Авто зогсоолын хүрээнд	-	-	-	0.2	2025 онд	Хог хаягдлын тухай хууль 2017 он Амьтны тухай хууль 2012 он
15	Хог хаягдлыг амьтанд хоргүйгээр шийдвэрлэх	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-	-	-	Хог хаягдлын мененжментийн зардалд	2025 онд	
16	Амьтанд гэмтэл учруулах, тоо толгой хорогдох	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	Төсөл хэрэгжих хугацаанд	-	-	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан	2025 онд	
Нийт сая.төг			10.0 сая.төгрөг						

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Нөхөн сэргээлт	“Зараа” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах бөгөөд эвдрэлд өртөх талбай бага учир 2025 оны техникийн нөхөн сэргээлтийн ажлыг сум орон нутгаас санал авсны дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр шийднэ.	Төслийн талбай	-	-	-	2025 онд	MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт дүн, сая.төг			-					

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Орон нутгаас авсан саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх /Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 50 ш мод тарих/	Үйл ажиллагааны хүрээнд	50	—	2.0	2025 онд	MNS 5914:2015, MNS 4597:2013
Нийт дүн, сая.төг		2.0					

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2025 оны БОМТ-д нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

БҮЛЭГ 9.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал сая.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Төсөл хэрэгжих үед	-	-	1.1	2025 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2		Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох / Гал унтраах багаж хэрэгсэл, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт /	Төслийн ажилчдын кемпийн хүрээнд	-	-	1.0	2025 онд	
3	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Төсөл хэрэгжих үед	-	Сөрөг нөлөөллийг бууруурах арга хэмжээнд тусгасан		2025 онд	
4		Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд 1 удаа зохион байгуулах	Төсөл хэрэгжих үед	-	-	1.0	2025 онд	
	Нийт зардал (сая.төг)			3.1				

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал сая.төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	1.0	2025 онд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	Ажилчдын байр	0.41	2025 онд	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	0.5	2025 онд	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Үйл ажиллагааны турш	0.5	2025 онд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	ҮАЗ-д тусгасан	2025 онд	
Нийт дүн сая.төг			2.41		

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
1	Хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2-3 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	-	0.3	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. (2008). Монгол улсын стандарт - MNS 5850:2008. Улаанбаатар.
2	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Төслийн талбайд 2-3 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	-	0.35	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга. (1991). Монгол улсын стандарт - MNS 3310:1991. Улаанбаатар.
3	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх	Төслийн ажилчдын кемпийн орчимд	Төслийн талбайд 2-3 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	-	0.35	Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга. (2012) MNS 6341:2012. Улаанбаатар. 14Хөрс. Гэдэсний бүлгийн нян ,гэдэсний бүлгийн халуун даадаг нян болон байж болох E.Coli-г илрүүлэх арга. (2004) MNS 5367:2004. УлаанбаатарMNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур жоншны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
4	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2025 он	Жилд 1 удаа	-	0.5	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Нийт зардал сая.төг					1.5			

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг сая.төг	Нийт зардал сая.төг	Хугацаа
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Далд уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		2025 он
2	Осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, зохион байгуулах	Далд уурхайн хүрээнд	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан		2025 он
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ-д хүргэн өгч байх	Аж ахуй нэгжийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 11 сард
4	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Далд уурхайн хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр		2025 он
5	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Далд уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
6	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Нийт ажиллагсдад	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Нийт ажиллагсдад	-	1.0	2025 он
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				1.0 сая.төг	

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн дүүргийн иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийж байх шаардлагатай болно.

Хүснэгт 11. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Сүхбаатар аймгийн Байгаль орчны газарт	Цахим болон бичгээр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хянуулах	2025.он	Дотоор төлөвлөлтөөр	“Ананд баян тал” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цахимаар					Цахим системд
Нийт		-				

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн “Зараа” хайлуур жоншны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 20'010'000 төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	10.0
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	2.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3.1
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.41
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.5
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1.0
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		20.01